

Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

27.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.1.1. эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез, ортопед үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 44 000-110 000 төгрөг;

27.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг

27.1.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, хугацааг сунгахад 200 000 төгрөг;

27.1.4. эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 120 000-400 000 төгрөг;

27.1.5. биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

27.1.6. өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ арга турших, нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 8000-20 000 төгрөг.

27.2. Өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.2.1. импортын лиценз олгоход 6000-12 500 төгрөг;

27.2.2. экспортын лиценз олгоход 6000-12 500 төгрөг.

27.3. Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг хураана.

27.4. Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.4.1. анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн их эмчид хоёр жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 4000-10000 төгрөг;

27.4.2. мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцсэн эм зүйч, эм найруулагч, хүний бага эмч, эх баригч, сувилагч болон энэ хуулийн 27.4.1-д заасан зөвшөөрлөөр хоёр жил ажилласан эмчид 5 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 2000-5000 төгрөг;

27.4.3. анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эмчлэх, эм барих, сувилахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгоход 120 000-400 000 төгрөг.

[/Энэ зүйлийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)